

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны  
05 дугаар сарын 21-ний өдрийн  
60 дугаар тогтоолын хавсралт

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ  
БЭХЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР /2014-2016/**

**Нэг. Нийтлэг үндэслэл:**

Ховд аймаг нь Засаг захиргааны 17 сум, 84 багтай. 76,1 мянган кв.км газар нутагтай, 80217 хүн амтай, 20063 өрхтэй бөгөөд 14 сумын эрүүл мэндийн төв, 1 нэгдсэн эмнэлэг, 1 сум дундын эмнэлэг, 6 өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүн амд хүргэж байна.

2013 оны үзүүлэлтээс нийт эмчлүүлэгчдийн 8376 буюу 41.8 хувь нь сумын эрүүл мэндийн төвөөр эмчлүүлсэн байна.

Ховд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллага нь хүн амын тоо, стандартад заасны дагуу 2-13 их эмчтэйгээр ерөнхий мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Өнөөгийн байдлаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд цус, шээсний ерөнхий шинжилгээ, биохими, элэгний В,С вирусын маркер үзэх, хурдавчилсан оношлуураар БЗДХ, ХДХВ-ын халдвар, хэвлийн хөндийн цуллаг эрхтэний дүрс оношлогоо зэрэг нотолгоонд тулгуурласан үйлчилгээг үзүүлж, зарим нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангагдаж эмч, мэргэжилтнийг богино хугацааны сургалтанд хамруулж чадавхижууллаа.

Гэвч сум, орон нутагт оношлогоо, шинжилгээний урвалж бодисын хангалт дутмаг, пульсоксиметр, хяналтын монитор, шарлагын аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат зэрэг зарим нэн шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж дутмагаас төв рүү ирж эдгээр шинжилгээнд хамрагддаг, түүнийг нийлүүлэх санхүүжилтийн хүрэлцээгүйгээс тусламж үйлчилгээний тасралтгүй, тогтвортой байдал хангагдаж чадахгүй байна.

Сумаас аймгийн төвд үйлчлүүлэх иргэдийн чирэгдлийг багасгаж, иргэдийн орон нутагтаа үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж зарим шаардлагатай оношлогоо шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах, сум өрхийн эрүүл мэндийн төвийн барилгад засвар, өргөтгөл хийх, багийн эмчийг унаагаар хангах зэрэг иргэдийн нэн шаардлагатай эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг

өргөжүүлж, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгаас тусгасан тодорхой зорилтуудыг шийдвэрлэх зорилготойгоор хөтөлбөрийг боловсрууллаа.

#### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго.**

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэдийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж үр ашгийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Гурав. Хөтөлбөрийн зорилтууд.**

1. Сумын эрүүл мэндийн төвд нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний тусламж үйлчилгээний орчин нөхцөл, хүртээмжийг сайжруулах

2. Эмч, мэргэжилтнүүдийг сум, өрхийн анагаах ухаан, удирдахуйн менежментээр сургаж мэдлэг, ур чадварыг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллуулах.

3. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болох Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх.

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсвийн төлөвлөгөө**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	шаардагдах төсөв (сая-аар )	Эх үүсвэр
<b>Зорилт 1. Сумын эрүүл мэндийн төвд нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний тусламж үйлчилгээний орчин нөхцөл, хүртээмжийг сайжруулах</b>				
1.1	Дуут, Үенч, Дарви, Мөст, Цэцэг, Манхан, Ховд, Чандмань, Дөргөний зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангах.	ЗДТГ-ын НХХ,	29.7	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
1.2	Судалгааг үндэслэн 16 суманд УВЧ, ургийн доплер. нярайн дулаацуулах ширээ, хүчилтөрөгийн аппарат олгох	ЗДТГ-ын НХХ, ЭМГ	14.9	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан,
1.3	Булган, Зэрэг, Эрдэнэбүрэн, Дарви, Алтай, Манхан, сумдыг гематологийн аппарат, автоклаваар хангах	ЗДТГ-ын НХХ, ЭМГ	30.6	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан,
1.4	Булган, Манхан сумдад шүдний эмчилгээний кабинет байгуулж ажиллуулах	ЭМГ	40.0	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан
	Булган сумын Нэгдсэн эмнэлэг,	ЗДТГ, ЭМГ,		Улсын төсвийн

1.5	Дуут сумын эмнэлгийг шинээр барих		2650.0	хөрөнгө оруулалт
1.6	Мөст, Үенч, Алтай, Мянгад сумын өргөтгөл	ЭМГ, Аймгийн ЗДТГ,	2180.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
1.7	Буянт Цэцэг, Дөргөн, Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань сумын эрүүл мэндийн төвийн засвар	ЭМГ, Аймгийн ЗДТГ,	1680.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
1.8	Баатархайрхан, Бугат өрхийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Булган өрхийн Эрүүл мэндийн төвийн засвар	Аймгийн болон Жаргалант сумын ЗДТГ, ЭМГ,	1000.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
1.9	Ховд, Булган, Дарви, Дуут Мөнххайрхан сумын түргэн тусламжийн машиныг шинэчлэх	ЭМГ, Аймаг, сумын ЗДТГ,	60.0 40.0	Улсын төсөв, сумын орон нутгийн хөгжлийн сан
1.10	Булган, Буянт, Дарви, Мөнххайрхан, Үенч, Алтай, Мөст, Цэцэг, Манхан, Чандмань, Мянгадын Эрүүл мэндийн төвийн гал тогоог иж бүрэн цахилгаан тоног төхөөрөмжөөр хангах	ЭМГ, Аймаг, сумын ЗДТГ,	33.0	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан
1.11	Сумын эрүүл мэндийн төвийг интернетэд холбох	Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ	32.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
1.12	Багийн эмч нарыг дэс дараатайгаар унаагаар хангах	Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ	28.8	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан
1.13	Зарим сум болон өрийн эрүүл мэндийн төвийг цэвэр бохирт холбох	Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ	3500.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

**Зорилт 2. Эмч, мэргэжилтнүүдийг сум, өрхийн анагаах ухаан, удирдахуйн менежментээр сургаж мэргэшүүлэн мэдлэг, ур чадварыг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллуулах**

2.1	Сумын эрүүл мэндийн төвийн их эмч нарыг өрхийн анагаах ухааны давтан сургалтанд хамруулах	ЭМГ, ЭМХҮТ, Сумын ЗДТГ, ЭМТ	6.0	Дотоод нөөц
2.2	Сумын эрүүл мэндийн төвийн бага эмч, сувилагч нарыг өрхийн анагаах ухааны давтан сургалтанд хамруулах	ЭМГ, ЭМХҮТ, Сумын ЗДТГ, ЭМТ	10.0	Дотоод нөөц
2.3	Сумын эрүүл мэндийн төвийн асрагчийг сувилахуйн сургагчаар бэлтгэх	ЭМГ, ЭМХҮТ, Аймаг, сумын ЗДТГ,	2.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
	Сумын эрүүл мэндийн төвийн	ЭМГ,		ЭМХҮТ,

2.4	эмч, мэргэжилтнүүдэд зориулсан зайн сургалтыг зохион байгуулах		3.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
2.5	Сургалтын хэрэгцээг үндэслэн давтан сургалт зохион байгуулах	ЭМГ, ЭМХҮТ,	1.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
2.6	Сумын Эрүүл мэндийн төв бүр эмч, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж мөрдөх	ЭМГ, ЭМХҮТ, Сумын ЗДТГ	00	ЭМХҮТ, Дотоодын нөөц,
2.7	Сумын эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн төлөвлөгөөг сумын онцлогт үндэслэн боловсруулж ажиллах	ЭМГ, Сумын ЗДТГ, сумын ЭМТ	0.5	Дотоод нөөц,
2.8	Сум бүр хүний нөөцийн төлөвлөгөөнд түшиглэн эмч мэргэжилтнээ сурган суурьшуулах бодлого боловсруулж мөрдөх	ЭМГ, Сумын ЗДТГ, сумын ЭМТ	3.0	Дотоод нөөц,
2.9	Эмч мэргэжилтнийг зүрхний цахилгаан бичлэгийн хариуг унших чадавхижуулах сургалтанд хамруулах	ЭМГ, сумын ЭМТ	2.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр

**Зорилт 3. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болох Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх**

3.1	Сумын иргэйн оролцоотой эрүүл мэндийг дэмжих бүлгийг байгуулж тогтмол үйл ажиллагаа явуулж урамшуулах	ЭМГ, Сумын ЗДТГ, сумын ЭМТ	1.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
3.2	Эрүүл мэндийн сайн санааны туслагч, идэвхитнүүдийг бэлтгэж Нийгмийн эрүүл мэндийн ажилд татан оролцуулах	ЭМГ, Сумын ЗДТГ, сумын ЭМТ	1.5	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
3.3	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага хамт олон, өрх, гудамж шалгаруулж урамшуулах	ЭМГ, Сумын ЗДТГ, сумын ЭМТ	5.0	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан
3.4	Хүүхдийн амны хөндийн эмгэгийг эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан	45.0	Сумын орон нутгийн хөгжлийн сан
3.5	Халдварт бус өвчний эрт илрүүлгийг чанартай хийж эрүүлжүүлэх, хяналтанд авах ажлыг тогтмолжуулах	Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан	32.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
	Нийгмийн эрүүл мэндийн	ЭМГ, Аймаг,		Аймаг, сумын

3.6	компанит ажлыг сум бүр улиралд нэг удаа олон нийтийг хамруулан зохион байгуулж хэвших	сумын НЭМ-ийн зөвлөл	50 .0	орон нутгийн хөгжлийн сан
3.7	Орон нутгийн хэвлэл мэдээллээр үйл ажиллагааг сурталчлан иргэдэд хүргэх	ЭМГ, Аймаг, сумын НЭМ-ийн зөвлөл	3.0	Дотоод нөөц, төсөл хөтөлбөр
• Улсын төсөвөөс			11 102 000 000	
• Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан			272 000 000	
• Байгууллагын дотоод нөөц, төсөл хөтөлбөр, хандив			65 000 000	
НИЙТ ДҮН			11 439 000 000	

### **Тав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн.**

1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэж, нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээ шинээр нэвтрэн, үйлчлүүлэгчид ээлтэй, орчин нөхцөл сайжирна.

2. Сум, өрхийн хүний нөөцийн хэтийн бодлого төлөвлөлттэй болж, эмч нарыг чадавхижуулах тогтолцоо нэвтэрч хэрэгжсэн байна.

3. Сум бүрт нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулах тодорхой арга барил бий болж, эрсдэлд хүргэх хүчин зүйлээ тодорхойлж, бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг болно.

### **Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Аймгийн Эрүүл мэндийн газар нь аймаг, сумын Засаг даргатай хамтран “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах бөгөөд сум, орон нутгийн түвшинд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (дарга) хэрэгжилтийг хариуцаж ажиллана. Энэхүү хөтөлбөр нь олон талын оролцоотой хэрэгжих тул сумын Засаг дарга салбар хоорондын хамтын оролцоог идэвхижүүлэх үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлт	2013 оны түвшин	2016 онд хүрэх түвшин
Нэг. Сумын эрүүл мэндийн төвд нотолгоонд суурилсан оношлогоо, эмчилгээний тусламж үйлчилгээний орчин нөхцөл, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд			
1.1	Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангагдсан эрүүл мэндийн төвийн тоо	1	9
1.2	Шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалтын хувь	60	90-ээс дээш

1.3	Шүдний эмчилгээний кабинеттай сумын тоо	00	3
1.4	Шинээр баригдсан эмнэлгийн тоо	00	2
1.5	Өргөтгөсөн эмнэлгийн тоо	00	4
1.6	Засварласан эрүүл мэндийн төвийн тоо	0	6
1.7	Өргөтгөсөн, засварласан өрхийн Эрүүл мэндийн төвийн тоо	1	4
1.8	Шинэчлэгдсэн машины тоо	1	4
1.9	Гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн төвийн тоо	2	11
1.10	Интернетэд холбогдсон эрүүл мэндийн тоо	00	13
1.11	Унаагаар хангагдсан багийн тоо хувь	00	50
1.12	Цэвэр бохирт холбогдсон сум өрхийн эрүүл мэндийн төвийн тоо	00	9
Хоёр.Эмч, мэргэжилтнүүдийг сум, өрхийн анагаах ухаан, удирдахуйн менежментээр сургаж мэргэшүүлэн мэдлэг, ур чадварыг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд			
2.1	Өрхийн анагаах ухааны давтан сургалтанд хамрагдсан их эмчийн тоо	00	16
2.2	Өрхийн анагаах ухааны сургалтанд хамрагдсан бага эмч, сувилагчийн тоо	00	42
2.3	Сувилахуйн сургалтаар бэлтгэгдсэн үйлчлэгчийн тоо	12	40
2.4	Зайн сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний хувь	20	100
2.5	Давтан сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний хувь	15	100
2.6	Шинэчилсэн ажлын байрны тодорхойлолт сумын тоогоор	00	16
2.7	Хүний нөөцийн бодлого, төлөвлөгөөтэй ажилладаг сумын тоо	00	8
2.8	Чадавхижуулах сургалтанд хамрагдсан сумын эмчийн хувь	10	90
Гурав.Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болох Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд			
3.1	Байгуулагдсан бүлэг, нөхөрлөлийн тоо хувь	00	20
3.2	Шинээр бэлтгэгдсэн сайн санааны туслагч, идэвхитнүүдийн тоо хувь	24	56
3.3	Шалгаруулж урамшуулсан хамт олон, өрх, гудамжийн тоо	00	24
3.4	Хүүхдийн амны хөндийн эрүүлжилтийн хувь	20-30	80
3.5	Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хувь	35-40	80-аас дээш
3.6	Компанит ажил зохион байгуулсан тоо (нэг сум жилд 4 удаа)	6	68
3.7	Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр Нийгмийн эрүүл мэндийг сурталчилсан тоо	Улиралд 2 удаа	Улиралд 4-өөс дээш

**Найм. Хугацаа.**

Хөтөлбөрийг 2014-2016 онуудад хэрэгжүүлнэ.

**Ес. Хяналт шинжилгээ, үнэлгээ.**

Хяналт шинжилгээ, үнэлгээг хөндлөнгийн болон дотоодын хяналт үнэлгээгээр хийж болно.

Мөн явцын хяналт үнэлгээг аймгийн төрийн Захиргааны болон мэргэжлийн байгууллага хариуцан холбогдох бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

.....оОо.....